

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 15.00 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Мягмардаш, Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Дуламсүрэн, Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дамбапэлжээ, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Нээлттэй нийгэм форумын менежер, ажлын хэсгийн гишүүн Н.Дорждарь, Ил тод сангийн тэргүүн н.Цэрэнжав, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, Мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн институтын ерөнхийлөгч Л.Дондог, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Үндэсний татварын ерөнхий газрын ажилтан н.Эрдэнэбаатар, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн н.Цэгц, Газрын тосны газрын хэлтсийн дарга н.Чулуунбат, МАК-ийн ажилтан н.Билигсайхан, Монросцветмет ХХК-ийн мэргэжилтэн Я.Дашдондог, Бороо гоулд ХХК-ийн ажилтан н.Ганхөлөг, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Ерөнхийлөгчийн зөвлөх А.Эрдэнэдорж, Миний монголын газар шороо хөдөлгөөний ажилтан С.Отгон, Байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын холбооны ажилтан А.Амгалан нар оролцов. Хуралдаанд ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг, Эрнст энд Янг Монголиа Аудит компанийн захирал Александр Чин, менежер Питер Вонг, ахлах аудитор Г.Алтансүх, аудитор Л.Оюу-Эрдэнэ, Б.Энхтуул нар оролцов. Хуралдааны ирц 80 хувьтай байлаа.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Б. Эрдэнэсүрэн нээж хэлэхдээ Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн ажлын хэсгийн хурлаар дараахь хоёр асуудлыг хэлэлцэнэ:

1-д Монголын Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын Санаачлагын 2007 оны нэгдсэн тайлан, тодруулга хийсэн тухай Малайз, Монголын Эрнст Янг аудитын компаниудын консорциумын аудитор Г. Алтансүхийн танилцуулгыг сонсч энэ тайланг Үндэсний зөвлөлийн хурлаар оруулах эсэхийг шийднэ.

2-т Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайланд бэлтгэх ажлын явц, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонгийн танилцуулгыг сонсч, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг батлана. Гэж танилцуулаад, хэлэлцэх асуудлаар гишүүдээс санал асууж, нэмэлт санал гараагүй тул дотоод журмыг танилцуулж, хуралдааныг 2 цагт багтаан хэлэлцэе гэв.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын Санаачлагын 2007 оны нэгдсэн тайлан, тодруулга хийсэн тухай Малайз, Монголын Эрнст Янг аудитын компаниудын консорциумын танилцуулга

Танилцуулгыг тус консорциумыг төлөөлж ахлах аудитор Г.Алтансүх хэлэхдээ би Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитороор ажилладаг. Өнөөдрийн хуралдаанд манай захирал Александр Чин, менежер Питер болон бусад аудиторууд ирсэн байна. Бид 2007 онд төсөвт төлсөн орлогооро тэргүүлсэн 38 компанийн тайлангуудад аудит хийж байгаа гэдгийг та бүхэн мэднэ. Түрүүчийн ажлын хэсгийн хуралдаанаас 9,0 тэрбумын зөрүүг олж тогтоохыг бидэнд даалгасны дагуу бид ажилласан. Энэ танилцуулгад орж амжаагүй 2-3 тодруулга байгаа. Дорнод, Сүхбаатар аймгуудаас өчигдөр, уржигдар л ирсэн тул энэ материалд оруулж чадаагүй гээд үзүүлэн харж тайлан, нэмэлт тодруулгын талаар танилцуулав Ажлын хэсгийн өмнөх хуралдаанаар хойш 6.0 тэрбум төгрөгийн зөрүүг тодруулга хийн шийдвэрлэж, бүгд зөрүү 14.0 тэрбум төгрөг, үүнээс олон улсын арбитрын шүүхэд маргалдаж байгаа Алтандорнод Монгол ХХК, тодруулга өгөх боломжгүй байгаа Тун синь ХХК-ийн зөрүүг хасвал 3.9 тэрбум төгрөгийн зөрүү гарсныг татвар, төлбөр, аж ахуйн нэгж бүрээр, зөрүү гарсан шалтгаан, өгч

байгаа зөвлөмж зэргийг дэлгэрэнгүй танилцуулав (Дэлгэрэнгүй тайланг гишүүдэд хүргүүлсэн байсныг хавсаргав).

Б.Эрдэнэсүрэн: За танилцуулсан тайлан, тодруулгатай холбоотой асуулт байна уу?

Н.Дорждарь: Ганц , хоёр юм тодруулъя. Болд төмөр ерөө голын төлсөн гээд байгаа 1.9 тэрбум төгрөг зөрүү болдог нь ямар учиртай вэ? Засгийн газар нь аваагүй гэж ойлгогдож байна? Татварын тайлбар үүн дээр байна уу? Мөн тэр Тун синь компанийн 1 тэрбум төгрөгийг тайлангаас хасъя гэдэг нь ямар учиртай юм бэ?

Г.Алтансүх: Тун синий зөрүү 1 тэрбумыг тайланд тусад нь харуулахаар өмнөх хуралдаан дээр тохирсон. Тун синий 1 тэрбум дээр нэмээд Алтан дорнод монголын 9 тэрбум , нийлээд 10 тэрбумыг тайлангийн зөрүүнээс тусад нь харуулахаар тохирсон байгаа. Болд төмөр ерөө голын хувьд 2007 оны 12 дугаар сарын 29-ний өдөр татварын дансанд 1,9 тэрбумыг шилжүүлсэн. Гэтэл татвар дараа ондоо оруулсан учраас энэ энэ зөрүү гарсан байх магадлалтай. Бид татвараас 2008 онд энэ мөнгө бүртгэгдсэн талаар лавласан боловч хүлээж аваагүй гэсэн захиаг авсан. Тэгээд бид энэ зөрүүг олох тал дээр мухардаад байна.

Б.Эрдэнэсүрэн: Татварынхнаас энэ талаар тайлбарлах юм байна уу?

н.Эрдэнэбаатар: Одоо шууд хэлэх юм алга. Баримтаа бидэнд өгчихвөл энэ талаар тодруулъя.

Н.Дорждарь-Либери Улсад нягтлан бодох нь 135 мянган ам.долларын татварыг хувийн дансандаа шилжүүлээд, тэр нь илэрч зрүүгийн хэрэг болсон жишээ гарсан байна. Бид ийм зөрүүг л олох ёстой юм. Гэтэл бид зөрүү байна гээд мэдэхгүй сууж болохгүй.

Б.Эрдэнэсүрэн: Монросцветмет дээр 989.0 сая төгрөгийн зөрүү гарсан харагдаж байна энэ ямар учиртай юм бэ?

Г.Алтансүх: Монросцветмет компанийн хувьд 1,2 тэрбумын зөрүү гарснаас Татварын ерөнхий газар 276.0 сая төгрөг хүлээж авсан гэсэн тул ийм зөрүү үлдэж, харин 900 гаруй сая нь тодроогүй үлдсэн.

Б.Эрдэнэсүрэн: Хасаад үлдэж байгаа нь 989.0 сая төгрөг юм уу?

Г.Алтансүх: Компани нь Төв аймаг, нийслэлд төлсөн гэдэг, үүнийг татварын байгууллага тодруулж чадаагүй.

Б.Эрдэнэсүрэн: Бороо гоулд дээр Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив 571 сая төгрөгийн зөрүү гарсан харагдаж байна. Энэ ямар учиртай вэ?

Г.Алтансүх: Орон нутаг болохоор Бороо гоулдаас 1 тэрбумыг бид авсан гээд мэдээлсэн байгаа. Бороо гоулд нь 471 саяыг өгсөн гээд мэдээлсэн байгаа. Бороо гоулд компани нь 471 саяынхаа задаргааг хүртэл гаргаж өгсөн, орон нутагт нь задаргаа байхгүй, бид 1 тэрбум төгрөг авсан нь үнэн гэсэн бичиг өгсөн. Энэ хоёрын дундаас 571 сая төгрөгийн зөрүү гараад байгаа юм.

Э.Сумъяа-Бороо гоулд компани орон нутгийг хөгжүүлэх сан Мандал, Баянгол суманд байгуулж 500, 500 сая төгрөгийн сан байгуулсан мэдээ бий. Үүнийг сумд нь сангийн нэрлэсэн дүнгээр мэдээлээд, компани нь гүйцэтгэлээр мэдээлсэн байх магадлалтай. Үүнийг шалгаагүй боллолтой.

Б.Эрдэнэсүрэн: Байгаль орчны яаман дээр энэ юун зөрүү вэ? Гачуурт бид 300 саяыг өгөөгүй гээд байхад яам нь үгүй чи энэ мөнгийг зарцуулсан гээд байдаг. Ямар учиртай юм бэ?

Г.Алтансүх: Байгаль орчин, аялал жуулчлалын яам бага мэдээ өгсөн. Тэд байгаль хамгаалах тайлан гэдгээс тоо авдаг бололтой. Тиймээс компаний мэдээнээс илүү гарсан зөрүү энд гараад байгаа юм.

А.Эрдэнэдорж: Ер нь иймэрхүү юм гардаг юм аа. Жишээ нь манай компани 100000 ам.долларыг байгаль хамгаалах санд нь байршуулдаг. Бид бол данснаасаа гаргасан юм чинь гарсан л гэж тайлбарлана шүү дээ. Гэтэл яам бид энэ мөнгийг чинь аваагүй тэр дансанд чинь л байж байгаа гэдэг. Бид нөхөн сэргээлт энэ тэрээ хийчихээд буцаад мөнгөө тэр данснаас нь авах болохоор ханшийн зөрүү энэ тэр гээд нөгөө 100000 маань 86000 доллар болчихож байгаа юм.

Г.Алтансүх: Байгаль хамгаалахад зарцуулсан энэ дүн бол аль нэг байгууллага яг хүлээж авсан дүн биш учраас, зүгээр л нэг таамаг маягийн тоо байгаад байна уу гэж бодогдсон. Яг компаний хэдэн төгрөг зөрсөн гэдгийг яам мэдэх боломжгүй, мөн нэгдсэн бүртгэл байдаггүй учраас ийм таамаг маягийн тоо тайлан дээр тавигдаад байна.

Б.Эрдэнэсүрэн: Байгаль хамгаалах санд орсон мөнгийг шалгасан уу, сангаас мөнгө авч зарцуулсан байна уу?

Г.Алтансүх-Байгаль хамгаалах санд байршуулсан мөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам мэдэхгүй байсан тул Сангийн яамнаас тодруулга авсан, энэ тоо компанийхтай тохирч, зөв байна лээ.

Б.Эрдэнэсүрэн: Байгаль хамгаалах зардал Засгийн газрын тайлан илүү байна. Энэ бол ойлгомжгүй бөгөөд утгагүй зүйл байна.

Г.Алтансүх-Байгаль хамгаалах зардлын мөнгийг Засгийн газар хүлээж авах мөнгө биш ээ. Компани л байгаль хамгаалах зорилгоор зарцуулсан мөнгөний мэдээ. Засгийн газар буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам компаниудын байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээс авч тавьсан гэдэг. Тэгэхээр компаниудын 2 мэдээ зөрж байгааг харуулж байна.

Д.Дамбапэлжээ: Компанийн тоо бол яг гүйцэтгэлийн тоо, төрийн байгууллагууд өөрсдийн тоогоо л тавьж байгаа биз дээ.

Л.Дондог: Би үүнийг ингэж ойлгож байна. Компанийн тоо зөв. Гэхдээ компани өөрийн зарцуулснаасан 2, 3 дахин ихийг бичээд, бид байгаль нөхөн сэргээхэд ийм их мөнгө зарцуулсан шүү гээд яамандаа бичээд өгчихдөг. Нөгөөдүүл нь тэр тоог нь аваад энэ тайлан дээр тавьчихдаг. Эргүүлээд ОУИТБС-ын тайлан дээр компани яг баримтаар зарцуулснаа бичдэг, яам нь болохоор өнөө 3 дахин их дүнг нь биччихдэг. Үүнээс болоод зөрүү гарч байгаа гэж ойлгогдож байна. Дараахь зүйлийг асууя. Тайлан хэдэн компаниар гаргаж байгаа гэлээ.

Г.Алтансүх: Тулгалт 38 компани дээр хийгдэж байгаа.

Л.Дондог-Та нар 10 гаруй тэрбумын зөрүү шийджээ, 10 гаруй тэрбумын зөрүү үлдсэн байна. Үүнийг юу гэж ойлгох вэ?

Г.Алтансүх-Бид өнөөдөр 9 дүгээр сарын 11-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаас хойш шийдвэрлэсэн дүнгээ голлож ярьсан. Ер нь анх зөрүү 90.0 тэрбум байсныг тулгалт хийх замаар энэ үзүүлэлт гарч байгааг ажлын хэсгийн өмнөх 2 хуралдаан дээр танилцуулсан байгаа.

Л.Дондог-Зөрүүг "О" болтол та нар ажиллах ёстой. Үүнээс компанийн ажилтан залилж уу, төрийн албан хаагч авилгалд жүү гэдэг гарна.

Г.Алтансүх-Бид гэрээ, удирдамжийн дагуу ажилласан. Бид ямар цэрэг, цагдаа биш компанид ч, төрийн байгууллагуудад шууд нэвтрэх, баримтыг шалгах эрх байхгүй шүү дээ.

Л.Дондог-Гэрээнд зөрүүг бүгдийг гарга гэсэн үү. Болохыг нь л зөрүүг тодорхойл гэсэн үү?

Ш.Цолмон- Гэрээнд 1 дүгээрт тайланг нэгтгэх, 2 дугаарт зөрүүг тодорхойлох, 3 дугаарт зөрүүг тулгаж шийдвэрлэх, компани бүрээр, татвар, төлбөр бүрээр зөрүү байгаагийн шалтгааныг олох, цаашид үүнийг арилгах зөвлөмж өгөх үүрэгтэй. Сэжигтэй, шаардлагатайг үзэх гэсэн үг бий. Энэ тайланд 770 тэрбум төгрөгийн нэгтгэл хийж байгаа, энэ нь улсын төсвийн 40 гаруй хувь юм. Бүтээгдэхүүний хувьд боломжтой, цаашид яаж шийдэхийг Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл, Авилгалтай тэмцэх газар гэх зэргээр шийднэ. Нигэри Улсад тайлангийн зөрүүнээс гэмт хэрэг ч илрүүлсэн байгаа. Тайлангийн маягтын хувьд үзүүлэлт олон байна гэдэг юм билээ.

Н.Дорждарь: Би энэн дээр нэг юм сануулаадахъя. 2006 оны тайлангий зөрүүг аудит 25 тэрбумыг тодруулж чадахгүй нь гээд үлдээсэн. Үндэсний зөвлөлийн хурлаас Үндэсний аудитын газраар шалгуулъя гэж шийдвэрлэсэн. Гэтэл Үндэсний аудитын газар өөр дээрээ 6 сар байлгаж байгаад бид чадахгүй нь ээ, манай ажил биш ээ гээд буцаачихсан.

Л.Дондог: Тэр үнэндээ Үндэсний аудитын газрын буруу биш шүү дээ. Тэдний үүрэг ч биш. Тэд нар ийм бүдэг бадаг юм руу орохгүй ш дээ. Тэгэхээр нэгэнт мөнгө төгрөгийг нь төлж байгаагийн хувьд энэ аудитуудаараа л сайн юмаа гаргуулж тодруулж авах хэрэгтэй. Бид л эндээ учраа олох ёстой. Уг аудитыг улам нарийсгах нь зөв байх.

Х.Ганбаатар-Та бүхэн 99 тэрбум зөрүү шийдсэн л гэнэ, 14 тэрбум төгрөгийн зөрүүг ер нь яаж шийдэх вэ? Тэр 14 тэрбум д чинь ноцтой зүйл байна уу.

Г.Алтансүх-Тодруулга өгөөгүй хүндэтгэх шалтгаантай 2 компанийг хасвал 3 тэрбум гаруй төгрөгийн зөрүү байгаа. Шийдсэн гэдэг нь хоёр талаас нэмэлт тодруулга авч тоог нь баталгаажуулсан юм. Мөнгө ашигласан эсэхийг мэдэхгүй.

Х.Ганбаатар-Үүнийг тэгээд хэн тогтоох юэ?

Г.Алтансүх-1 дүгээрт бидэнд хугацаа байхгүй, хоёрдугаарт данс шалгах эрх бидэнд байхгүй.

н.Эрдэнэбаатар: Монросцветмет болон Болд төмөр ерөө гол дээр үзүүлэлтүүд нь манайтай зөрсөн байна. Баримтуудын хуулбар нь байна уу? Баримтын хуулбар байвал шалгах амархан.

Г.Алтансүх: Бидэнд гарын үсэг, тамга тэмдэгтэй компаниудаас ирүүлсэн бичиг байгаа.

н.Эрдэнэбаатар: Тэгвэл тэрийгээ бидэнд өгчих. Бид хөөж олъё.

Б.Эрдэнэсүрэн: Ер нь та нарын ажлын явцад харагдсан хамгийн сайн идэвхтэй ажилласан 5 компаниуд, ажил хүндрүүлсэн 5 компанийн нэр, хамгийн сайн ажилласан төрийн байгууллага, хамгийн муу ажилласан төрийн байгууллага гээд тодруулаад өгчихмөөр байна. Компаниудаас хандив авсан яам, агентлаг, аймаг, сумыг нэрээр өгч болох уу. Мөн эргэлзэж байгаа, анхаарал татсан хандивын талаар нэрлэж болох уу.

Г.Алтансүх-Томоохон зөрүүг компани бүрийн нэрээр гаргасан байгаа. Сайн, мууг одоо нэрээр хэлж чадахгүй нээ. Үндэсний зөвлөлийн хуралдаанд тайланг оруулахаас өмнө гаргаж өгье.

Б.Эрдэнэсүрэн-Энэ ажлын дүнг ер нь Та нарын үгээр хэлэх нь зөв байх.

Г.Алтансүх- Би шууд энэ нь сайн байсан, тэр нь муу байсан гэсэн юм бэлдээгүй л дээ. Зүгээр өөрийн ажил хийх явцад анзаарагдсан зүйлүүдээ одоо ч хэлж болж л байна. Татварын

ерөнхий газар гайгүй ажилласан ч, яах вэ ажилласан, хүн хүч байдаггүй ч юм уу, хавсарч хийдэг болохоор ч тэр юм уу хэцүү байсан байх, дороос мэдээлэл авах систем нь муу, Гаалийн ерөнхий газар мэдээлэл сайн гаргаж өгч байсан, гаалийн мэдээлэл бол маш сайн байсан. ихэнх компаниуд тэгж ажиллаж чадахгүй байсан, Байгаль орчин, аялал жуулчлалын яам зардлаа гаргахад хүнд байсан. Компаниуд дотроос Тавантолгой эд нар бол ёстой зовоосон шүү.

Б.Эрдэнэсүрэн- Та нар үүнийг хэлж өгөх ёстой. Та нараас өгсөн мэдээллийг бид хаяхгүй ээ, хамгийн сайн байсныг нь Ерөнхий сайдын гарын үсэгтэй өргөмжлөлөөр шагнаж, нэр хүндийг нь өргөж, муу байсныг нь нэр төрд сонин хэвлэлээр халдаж бусдад зарлах хэрэгтэй. Түүнээс гадна сэжиг бүхий зөрөөнүүдийг Үндэсний аудитын газар, Авилгалтай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар гэх мэт хянах шалгах эрхтэй байгууллагуудад нь өгч зохих журам дүрмийн дагуу шалгуулна. Харин тэдэнд өгөх мэдээлэл маань тодорхой байх хэрэгтэй.

Б.Эрдэнэсүрэн-За гишүүд тайлангийн талаар саналаа хэлэе.

Ганхөлөг-Энэ хурал бол гэм буруутныг олж тогтоох шүүх хурал биш ээ гэдгийг хэлмээр байна. Бид эхлээд юунаас болж зөрүү гарч байгаагаа олох ёстой болохоос заавал хэн нэгний бурууг олж харах нь чухал биш гэж бодож байна. Юуны өмнө энэ толгой эргүүлсэн олон татвар, хураамжаа цөөлөх хэрэгтэй шүү дээ. Тов тодорхой гарын таван хуруунд багтааар болгож ойлгомжтой болгох хэрэгтэй. Хүн будилуулсан олон юмнуудаас чинь болж зөрж байна. Үүнийг цэгцэлж цөөрүүлэхгүйгээр энэ зөрүүнүүд гарсаар л байх болно. Би улсын байгууллагад, татварт олон жил ажилласан хүн. Сангийн яам, татвар, статистик гээд олон мэдээллийн тоо хэзээ ч нийлж байгаагүй. Хуучин мэдээ гаргасан хүн гарын үсгээ зурж баталгаажуулдаг байсан, тэр үед мэдээ зөрдөггүй, зөрсөн ч бага зөрдөг, хариуцах эзэнтэй байсан, одоо бол мэдээ нь сүлжээгээр ирээд хэд хэдэн оператор шивээд, нэгтгээд байна, мэдээг дурын хүн тоог өөрчлөх боломжтой, хэн алдаа гаргасан, хэн мэдээний тоог өөрчилсөн хариуцлага хүлээх эзэнгүй болсон. Компаниудаас өгсөн тоо бол худлаа гэж бодохгүй байна. Жишээ нь манай компанийн хувьд аваад үзэхэд нээлттэй хувьцаатай компани. Хувьцаа эзэмшигч бүр улирал бүр хувь нийлүүлэгчид нь хянах эрхтэй, дотоод аудит шалгадаг, мөн дотоод хяналт ч бас шалгана, өдөр бүрийн гүйлгээ нь Торонтод хянагддаг тогтолцоотой. Жилдээ албан ёсоор 4 удаа аудитын шалгалт ордог, хэн ямар тоо шивсэн, хэн зассан гээд бүх зүйл серверт хадгалагдаж байдаг. Бид тайлангаа гаргахын тулд маш олон хүнээр баталгаажсан тоог тавьдаг. Гэтэл улсын байгууллагаас авсан гээд байгаа тоо чинь ямар байна вэ? Хэн дуртай нь албан бусаар утсаар ч юм уу тоо авдаг, хэд хэдэн хүн шивдэг, дурын мэргэжилтэн, дарга нь тоог засдаг, дараа нь хэнээс гарсан нь мэдэгдэхээ больчихдог, замбараагүй, ямар ч хяналт, баталгаажилтгүй тоо л байгаа. Тэгэхээр зөрөхгүй яах юм бэ? Иймд мэдээ, тайлан гаргах дотоод үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай, тэр цагт зөрүү арилна.

Н.Дорждарь: Бид 2007 оны тайлан хэлэлцэж байгаа ч 2008 оныход мөн л ийм зөрүү гарна. 2009 оны тайлангийн өмнө маягтаа өөрчлөх хэрэгтэй байна. Би энэ Тунь син компанийн тайлангийн зөрүүг тайлангаас хассаныг зөвшөөрөхгүй байна. Алтандорнод монголыг бол одоо арбитр дээр маргаж байгаа гэж бодохсон. Монгол газар компанийн асуудлыг ч тайланд нэр зааж дурдах хэрэгтэй.

Х.Ганбаатар: Би энэ Эрнс Янг-ийн хийсэн тайланг тун чамбай тайлан болж гэж бодож байна. Тэгэхээр үндэсний зөвлөлд танилцуулаад Засгийн газрын хуралдаанаар ч юм уу оруулж шийдвэр гаргаж ажилламаар байна. Тэгэхгүй бол ийм юм хийлгэхийг хаячихвал тун хайран юм болно шүү дээ. Мөн томоохон зөрүү гарсан газруудыг эдийн засгийн цагдаад өгчихвөл болно гэж бодож байна. Үзүүлэлтийг цөөлөх үүднээс хандив гээч юмыг хасвал яасан юм бэ? Зөвхөн хуулиар тогтоосон татвар, төлбөрийг тайлагнадаг болгох, Авах ёстой зүйлүүдээ авснаа ч сайн бүртгэж чадахгүй байж, албан бус ийм юман дээр бас баахан будилаан үүсгэх хэрэг байгаа юм уу?

Н.Алагаа: Хандив бол өгч байгаа нь үнэн, нэлээн том үзүүлэлт шүү. Харин үүний оронд тэмдэгтийн хураамж зэрэг жижиг зүйлийг маягтаас хасах хэрэгтэй. Компаниуд тэр байгууллага

ийм юм нэхээд байна, авилгал авах гээд байна гээд л байдаг. Гэтэл тэр нь үнэхээр байгууллагадаа очоод байна уу, авилга болоод байна уу гэдгийг хандив гэсэн үзүүлэлт бас харуулна шүү дээ. Энэ удаагийн аудит бол өмнөхөөсөө дэвшилттэй болсон. Тэр 1,9 тэрбум данснаас гараад яагаад алга болов гэх мэт юмыг тодруулах хэрэгтэй байна. Компани төлсөн гээд байгаа Засгийн газрын байгууллагууд аваагүй гээд байгаа зүйлийг түүж шалгуулах нь зүйтэй.

Л.Дондог: Нэгдүгээрт, энэ маягтыг өөрчлөх шаардлага харагдаж байна. Хоёрдугаарт, энэ тайлан бол түрүүчийн тайлангаас урагш ахисан тайлан гэдэгтэй санал нэг байна. Гэхдээ тайланг компаниас гаргасан нотолгоотой нь авч үлдээ, тэр тодруулга хийгдээгүй дүн дээр ажлын хэсэг ч юм уу, зөвлөх компани хөлслөөд ч юм уу ажиллуулмаар байна. Ингэж байж ялгаж, салгах, тэгэхгүй бол учир нь ч олдолгүй ингээд л хаягдчихна. Гуравдугаарт, үлдсэн тэр 30 орчим компанид аудит оруулмаар байна. Бид түрүү жил 3000 ам.доллараар 20 орчим компанийн тулгалтыг хийсэн. Сайн тайлан болсон шүү. Гэхдээ 3000 ам.доллараар хийвэл ч өөрсдөө бараг мөнгө гаргах юм билээ. Үнийг нь арай өндөрсгөх хэрэгтэй. Дөрөвдүгээрт, энэ компани тоо гаргаж өгөхгүй байна, тэр байгууллага тоогоо гаргаагүйгээс зөрүү гарлаа л гэнэ. Тэгэхээр цаашдаа ер нь бид компани тайлан гаргаж өгөхгүй ээ гэвэл тэгээд яах юм бэ? Тэгэхээр хууль тогтоомжид оруулдаг юм уу яадаг юм бэ, бас зохицуулж өгөх хэрэгтэй. Үүнийг зохицуулахгүй бол цаашид тайлан гаргахгүй хандлага нэмэгдэнэ. Түрүүчийн хуралдаан дээрээс очоод дарга нь битгий мэдээ өг гэдэг шиг үйлдэл давтагдана шүү.

С.Мягмардаш: Нэгд, маягтыг сайжруулах хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байна. Тэгээд Сангийн сайд баталж байгааг өөрчилж Засгийн газрын тогтоолоор баталвал арай хүчтэй байх болов уу, хариуцсан байгууллагыг нь тодорхой болгох, Хоёрт, Болд төмөрийн 1,9 тэрбумын он дамжсан зөрүү гээд байгааг олох хэрэгтэй. Мөн сүүлд Дорнод, Сүхбаатараас ирсэн гээд байгаа зөрүүнүүдийг энэ тайландаа оруулах. Гарах шийдвэрийн төслийн гуравт тайлбарыг Баярцогтод танилцуулах, Мягмардаш хариуцах ч гэнэ үү нэг ийм юм орсон байна. Энэ арай болохгүй байх аа. Хариуцсан ажлын алба байна. Бид энэнийг хийгээд зөрүү тодруулах гээд явах нь зохимжгүй санагдаж байна.

Х.Ганбаатар: Ил тод байгаа компаниудыг урамшуулж өгөх хэрэгтэй, олон нийтэд мэдээлэх нь зөв. Тэр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээ компаниас илүү мөнгө зарсан гээд байгаа явдлыг шалгаж тодруулах хэрэгтэй. Мөнгийг нь хэрэглэхээд ийм өөр юм яриад байгаа юм биш байгаа. Нэн сонирхолтой асуудал.

Ш.Цолмон: Сангийн яам энэ ажлыг хийх хамгийн боломжтой байгууллага гэж бодож байна. Шуудхан хэлэхэд ажлын алба үүнийг хийхэд үнэхээр хүч мөхөсдөнө. Төрийн байгууллагууд болон харъяа агентлагуудаа зангидаж чадах байгууллага гэж Сангийн яаманд энэ ажлыг хариуцуулмаар байна. Сайд нь Үндэсний зөвлөлийн гишүүн, газрын дарга нь ажлын хэсгийн гишүүн тул бас хамаагүй ч хүмүүст хариуцуулж байгаа биш л дээ.

Л.Дондог-Зөвлөх компаниар шалгуулах нь зөв.

Ш.Цолмон-Үндэсний зөвлөлд Сангийн яамны тайлбар орох нь зөв байх.

н.Цэрэнжав: Зөрүүг тодруулахаас гадна гол учир шалтгаануудыг сайн гаргаж өгөх хэрэгтэй. Ерөнхийдөө бол Үндэсний зөвлөлд оруулахыг дэмжье.

Э.Сумъяа: Тайланг Үндэсний зөвлөлд оруулахыг дэмжиж байна. Гэхдээ үг үсгийн алдаа байна, байгууллагуудын нэрийг худлаа бичиж. Худалдаа, аж үйлдвэрийн яам ч гэх шиг Монгол Улсад байхгүй байгууллагын нэр яваад байна. Хандивын зөрүүнүүдийг тэр яам, агентлагт тэр компаниас өгсөн гээд тодорхой бичээд Цолмонд өгөх нь зүйтэй. Эхлээд ийм юмнуудаа бидэнд өгчих дараа нь бид Үндэсний зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх талаар хөөцөлдье. Нөгөө талаас Сангийн яаманд яагаад энэ зөрүүг тодруулах ажлыг даалгав аа гэвэл бид түрүү жил 25 тэрбумын зөрүүн дээр Үндэсний зөвлөлд дээр Ерөнхий сайд Сангийн яамнаас зөрүүг тодруул гэж үүрэг болгож гэж 4 хуудас тайлан авч Үндэсний зөвлөлийн хуралдаанаар

хэлэлцэж байсан уламжлал бий. Тэгээд Үндэсний аудитын газраар шалгуулна гэсэн боловч мухардсан. Тиймээс ер нь хууль зүйн хувьд Сангийн яамаа л барьж ажилласан нь дээр юм байна гэж бодож төсөл боловсрогдсон.

Б.Эрдэнэсүрэн-Тайлан сайн гаргасан компанийг урамшуулах хөрөнгийн эх үүсвэр бий юу?

Ш.Цолмон-Боломж бол байгаа.

Б.Эрдэнэсүрэн: За надад дараахь саналууд байна.

1. Энэ тайланг Үндэсний зөвлөлийн хурлаар оруулъя гэж бодож байна.

2. Үндэсний зөвлөлийн хуралд сайн бэлдье. Хамтраад энэ асуудлуудаа шийдүүлээд авъя. Бүр Засгийн газрын хуралдаанаас тогтоол гаргуулаад авбал хэрэгтэй байна.

3. Эрнст янгийнханд сануулахад Үндэсний зөвлөл дээр товч бөгөөд ойлгомжтой илтгэл тавих хэрэгтэй шүү. Аудитынхан тоо баримтаа цээжилсэн байлдаа, нэг тоо асуухаар эрээд л явчих юм. Танай засгийн газрын ийм байгууллага сайн байсан, энэ нь муу байсан гэдгийг ойлгомжтой хэл. Хуулинд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна гэдгээ ойлгуул. Сайн хийсэн байгууллагуудад өргөмжлөл өгье. Үндэсний зөвлөлийн хурлаар орсны дараа хэвлэл мэдээллээр сайн, мууг нь мэдээлье. Улсын Их хуралд ч бас мэдээлэл өгөх хэрэгтэй. Маягтыг бол өөрчлөвөл дахиад л нэг хэсэгтээ баахан будилна. Би бол гар хүрэх хэрэггүй гэж бодож байна. Харин маягтан дээр бөглөх заавар, зөвлөмжөө сайжруулах хэрэгтэй. Маягтын заавар муу байгаа нь Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, ажлын албаны 2, бид 4-ийн л муугийнх шүү. Ажлын албанаас зохион байгуулж байгаа тэр нийтийг хамарсан сургалт гээд л нэг юм хийдгээ больё. Компани болгон дээр очиж тайлбарлаж тулж ажиллах хэрэгтэй байна. Энэ жил компанийн талаас 12 дугаар сарын 29-нд тушаасан гэснээс гараад байгаа 1.9 тэрбумын зөрүү ирэх жилийн тайланд Засгийн газрын тайланд бас зөрүү болоод гарах байх.

4. Тэр аудитад ороогүй үлдэж байгаа компаниудын тайланг нэг аудитын компаниар хийлгэчих санал гарч байна. Бидэнд одоохондоо бэлэн мөнгө байхгүй байгаа.

5. Тэр татвар яагаад тоогоо гаргаж өгөхгүй байгаа юм бэ? Ажлын хажуугаар давхар хийнэ гэж юу юм бэ? Энэ чинь л ажил нь биз дээ? Компанийн татварт өгсөн дүн татварын хүлээж авсан дүнтэй нь таарахгүй гэж байгаа бол өөрсдийнх нь ажил муу байна гэсэн үг биз дээ? Энэ асуудал Татварын ерөнхий газраас хэзээ ч салахгүй.

6. Шийдвэрийн төсөл та бүхэнд тараасан, 3 күйлийг Сангийн яамны дүгнэлт гэдгээр засая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга-Монгол Улсын хоёр дахь удаагийн буюу 2007 оны нэгтгэл тайланг хангалттай гэж үзэж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж батлуулахаар тогтов.

2. Ажлын хэсгийн хуралдаан дээр гишүүдээс тайлантай холбогдуулан гаргасан саналыг тайланд тусгах талаар ярилцаж, тайлангийн үг хэллэг, найруулгыг хянах, алдааг засч найруулан Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгаж, Малайз, Монголын Эрнст Янг аудитын компаниудын консерциумын төлөөлөлд зөвлөмж болгов.

3. Тайлангаар гарсан Засгийн газрын байгууллагуудаас шалтгаалсан шийдэгдээгүй зөрүүний шалтгааны талаар Сангийн яамны дүгнэлт боловсруулж

Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ханган, Үндэсний зөвлөл (нарийн бичгийн дарга)-д өгөхийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Д.Мягмардаш-д даалгав.

Б.Эрдэнэсүрэн-За шийдвэрийн төслөө батлах уу,

Гишүүд- Тэгье.

Б. Эрдэнэсүрэн: За хоёр дахь асуудлыг Цолмон танилцуулна.

ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайланд бэлтгэх ажлын явц, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай

Ш.Цолмон: Миний танилцуулах энэ асуудал бол мэдээллийн чанартай жижиг асуудал. Бид 2008 оны тайланд аудит хийх компанийг сонгон шалгаруулах зараа тараасан байгаа. 2009 оны 10 дугаар сарын 26-ны дотор оролцох хүсэлтээ ирүүлэх ёстой. Ингээд 3 хоногийн дотор шортлистээ хийнэ. Харин 12 дугаар сарын дундуур сонгон шалгаруулалтаа хийнэ. Энэ үйл ажиллагааг явуулахын тулд Үнэлгээний хороог байгуулах шаардлагатай байна. Тэгэхээр энэ үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг өнөөдөр бид батлах ёстой. Энэ манай ажлын хэсгийн байгуулж байгаа 3 дахь үнэлгээний хороо. Хамгийн анхны буюу 2006 оны аудиторыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 3 талын оролцоотой боловч, төрийн байгууллагуудын төлөөлөл зонхилсон байдлаар байгуулж байсан бол 2007 оныхыг иргэний нийгмийн төлөөлөл зонхилсон байдлаар бүрэлдэхүүнийг нь сонгож байсан. Харин энэ 2008 оны аудиторыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог компанийн төлөөлөл зонхилсон байдлаар буюу дараахь гишүүдтэйгээр байгуулах саналыг оруулж байна. (Бүрэлдэхүүн, гарах шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан байв.) Хэрэв та бүхэн татгалзах зүйлгүй бол энэ бүрэлдэхүүнийг баталж өгнө үү?

Б.Эрдэнэсүрэн-Асуулт байна уу.

Б.Эрдэнэсүрэн-2008 оны тайлан шүү дээ. Эртхэн хиймээр байна.

Ш.Цолмон-Үнэлгээний хорооны журмаар ажилласан нөхцөлд 2010 оны 1 дүгээр улиралд аудит хийгдэнэ.

Н.Алгаа-Үнэлгээний хорооны даргыг өөр хүнээр хийлгэж болохгүй юү?

Ш.Цолмон-Эхний үнэлгээний хорооны дарга Засгийн газрын төлөөлөл, 2 дахь үнэлгээний хорооны дарга Төрийн бус байгууллагын төлөөлөл байсан, одоо 3 дахь хорооны дарга нь Компанийн төлөөлөл байх юм. Бид оролцогч 3 талаа ажилд тэгш оролцуулахад ихээхэн анхаарч байгааг та мэднэ.

Б.Эрдэнэсүрэн-Асуулт, санал байхгүй бол шийдвэрийн төслөө та бүхэнд тараасан хувилбараар хувилбараар батлах уу.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайлан гаргах аудиторын компаниудын концерциумыг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар тогтов:

Үнэлгээний хорооны дарга- Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа (Компаниудын төлөөлөл);

Үнэлгээний хорооны гишүүд: -Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Ш.Уртнасан (Засгийн газрын төлөөлөл);

-Төлсөн авсанаа нийтэл эвслийн зохицуулагч Г.Сэнгэлмаа (иргэний нийгмийн төлөөлөл);

-Монросцветмет ХХК- ийн Хэтийн төлөв, хөгжлийн мэргэжилтэн Я.Дашдондог (компанийн төлөөлөл);

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга- Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайлан гаргах аудиторын компаниудын концерциумын сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, үр дүнгээ Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн гишүүн, Үнэлгээний хорооны дарга Н.Алгаад даалгав.

Бүгд: Шийдвэрийн төслийг гишүүд бүгд батлая гэв.

Б. Эрдэнэсүрэн: За хуралдаанд идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Энэ хурлаас гарсан шийдвэрүүдийг протоколоор баталгаажуулъя. Үндэсний зөвлөлийн хуралдаанд ажлын алба сайн бэлдээрэй. За хуралдаанаа өндөрлөө дөө.

Ажлын хэсгийн хуралдаан 17 цаг 45 минутад дуусав.


Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Б. Эрдэнэсүрэн

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн:
ОУИТБС-ын Ажлын албаны
ажилтан



Т.Хүрэлчимэг

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс**

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“II. ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайланд бэлтгэх ажлын явц, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайлан гаргах аудиторын компаниудын концерциумыг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар тогтов:

Үнэлгээний хорооны дарга- Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа (Компаниудын төлөөлөл);

Үнэлгээний хорооны гишүүд: -Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Ш.Уртнасан (Засгийн газрын төлөөлөл);


-Төлсөн авсанаа нийтэл эвслийн зохицуулагч Г.Сэнгэлмаа (иргэний нийгмийн төлөөлөл);

-Монросцветмет ХХК- ийн Хэтийн төлөв, хөгжлийн мэргэжилтэн Я.Дашдондог (компанийн төлөөлөл);


Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга- Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайлан гаргах аудиторын компаниудын концерциумын сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, үр дүнгээ Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн гишүүн, Үнэлгээний хорооны дарга Н.Алгаад даалгав.” гэжээ.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч

 Б.ЭРДЭНЭСҮРЭН

Засгийн газрын ахлах референт,
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

 Э.СУМЪЯА